



АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ
ДАРГА НАРТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР**

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Барилгачдын талбай 13, Засгийн газрын XII байр,
Утас: 26-47-86, Факс: (976-51) 26-60-88
E-mail: info@inspection.gov.mn, http://www.inspection.gov.mn

2020. 11. 14 № 01/3085
танай _____ -ны № _____ -Т

Ундны ус, ариун цэврийн байгууламж,
хог хаягдлын аюулгүй байдлыг хангаж
ажиллах талаар

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай Засгийн газрын 178 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын даргын 2020 оны 11 дүгээр сарын 11-ийн өдрийн 20 дугаар тушаалаар баталсан “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээний удирдамж” болон ДЭМБ, НҮБ-ын хүүхдийн сангаас гаргасан “Ус, ариун цэвэр, эрүүл ахуй, хог хаягдлын менежмент болон COVID-19 техникийн товч танилцуулга”-д цэвэр, бохир усанд коронавирус 2-7 хоног амьдардаг ба халдвартай хүний өтгөн, бохир усанд коронавирусын (COVID-19) РНХ-ийн хэсгүүд тодорхойлогдсон мэдээлэл байгаа тул коронавирусын халдвараас хүн амыг урьдчилан сэргийлэх зорилгоор ус, ариун цэврийн байгууламж, хог хаягдлын менежментийн аюулгүй байдлыг хангаж ажиллах талаар дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Нэг. Ундны ус хангамжийн аюулгүй байдлыг хангаж ажиллах талаар:

1.1 Мэргэжлийн хяналтын байгууллагын хийсэн хяналт шалгалтын дүнгээр аймаг, нийслэл, сумын ундны усны эх үүсвэрийн 328 /38.4%/ худгийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн дэглэм зөрчигдөж, гадаргын болон гүний ус бохирдох нөхцөл бүрдсэн тул “Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны А230/127 дугаар хамтарсан тушаалаар баталсан Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам”-д заасан хэмжээгээр ундны усны эх үүсвэрт эрүүл ахуйн болон энгийн хамгаалалтын бүс тогтоох, дэглэмийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар тодорхой ажлыг зохион байгуулж ажиллах;

1.2 Төвлөрсөн ус хангамжийн усанд халдваргүйжүүлэлт хийх, хлорын мэргэшсэн операторчныг ажиллуулах, үлдэгдэл хлорын хэмжээг цаг тутам тодорхойлж, тэмдэглэл хөтлөн баталгаажуулж байх. Ундны усанд халдваргүйжүүлэлт хийдэггүй аймгууд хлоржуулах төхөөрөмж, үлдэгдэл хлор тодорхойлох багаж авах хөрөнгө мөнгөний асуудлыг яаралтай шийдвэрлэх;

1.3 Төвлөрсөн ус хангамжийн ус нөөцлөх сангийн угаалга халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, акт үйлдэн баталгаажуулах, сангийн тагийг цоожилж лацдах ба агааржуулалтын хоолойд малгайвч хийж гадны бохирдол орохоос урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх;

1.4 Төвлөрсөн бус ус хангамжийн худаг болон ус түгээх байрны ус нөөцлөх саванд 3 сар тутам угаалга халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэх;

09 05446

1.5 Аймаг, нийслэлийн төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр, ус түгээх байр, хэрэглэгчийн түвшинд ундны усны стандартад заасан давтамж, үзүүлэлтээр ус хангагч байгууллагын дотоодын хяналтын лабораторид шинжилгээ хийх;

1.6 Сумдын түвшинд Засаг даргын тамгын газар хариуцан ундны усны эх үүсвэрийн худаг бүрийн усанд улирал тутам аймгийн Мэргэжлийн хяналтын газрын лабораторитай гэрээ байгуулан нян судлалын шинжилгээ хийлгэх. Нян судлалын дээж авах савыг сумын эрүүл мэндийн төвд ариутгаж бэлдэх ба дээжийг лабораторийн болон эрүүл мэндийн ажилтан авна;

1.7 Аймаг, нийслэл, сумдын усанд хийсэн нян судлалын шинжилгээний дүнг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын орчны эрүүл ахуйн асуудал хариуцсан эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагчдад танилцуулж зөвлөгөө авна.

1.8 Төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрийн худаг болон ус түгээх байранд өдөрт 2-оос доошгүй удаа халдваргүйжүүлэх бодистой чийгтэй цэвэрлэгээ хийх, ус түгээх хоолойг бохирдлоос хамгаалан өлгүүр, хошуувчтай байлгах, ус түгээх хоолойн амсар болон хүний гар хүрдэг хэсгийн гадаргууг тогтмол халдваргүйжүүлэх арга хэмжээ авах; Халдваргүйжүүлэлтэд Клорсепт 17 0.02%, Гипохлорид натри 0.25%, Жавелион 0.015%, Кальцийн гипохлорид 0.25%-ийн уусмалыг тус тус хэрэглэнэ;

1.9. Ус түгээгч гарын ариун цэврийг тогтмол сахиж, олон нийтэд үйлчлэхдээ амны хаалт хэрэглэх;

1.10 Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газраас өрхийн түвшинд ундны усыг аюулгүй хадгалах, хэрэглэх, буцалгаагүй ус уухгүй байх талаар иргэдэд чиглэсэн зөвлөмжийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтиол өгөх;

1.11 Хөдөөгийн хүн ам хөдөө аж ахуйн зориулалтаар гаргасан /ундны бус/ эрүүл ахуйн шаардлага хангахгүй, баталгаажилтгүй усыг хэрэглэж байгаагаас уснаас шалтгаалах өвчин эмгэгт өртөх нөхцөл бүрдсэн тул ундны усны аюулгүй байдлыг хангах талаар тодорхой ажлыг зохион байгуулж ажиллах;

1.12 Байгууллага, аж ахуйн нэгж, иргэн хувиараа гаргасан худгийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс дотор бохирдуулагч эх үүсвэр байрласан, /энгийн бие засах газар, бохирын цооног гэх мэт/ барилга байгууламжгүй, шинжилгээ баталгаажилтгүй усыг унд, ахуйдаа хэрэглэхгүй байх;

Хоёр. Төвлөрсөн ба төвлөрсөн бус ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлыг хангаж ажиллах талаар:

2.1. Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т заасны дагуу ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын талаарх хууль тогтоомж, норм, стандарт, дүрэм, зааврыг үйл ажиллагаандаа мөрдөх;

2.2. Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1-д заасны дагуу хэрэглээнээс гарсан бохир усыг технологийн дагуу цэвэрлэж, татан зайлуулж, цэвэрлэсэн бохир усны аюулгүй байдалд дотоодын хяналтыг эрчимжүүлэх;

2.3 Аймаг, нийслэлийн халдвартын эмнэлгийн бохир усыг урьдчилан халдваргүйжүүлэлт хийж ариутгах татуургын төвлөрсөн шугамд нийлүүлэх;

2.4 Төвлөрсөн бохир ус цэвэрлэх байгууламжтай аймаг, сумдын цэвэрлэсэн бохир усаа хаяж буй хаягдлын талбайд мал, амьтан орохоос сэргийлж хашаажуулах, хашааны эвдэрсэн хэсгийг засаж сайжруулах

2.5 Аймаг, нийслэлийн цэвэрлэх байгууламжийн цэвэрлэсэн бохир усанд заавал халдваргүйжүүлэлт хийж, үлдэгдэл хлорыг тодорхойлж Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага" MNS 4943:2015 стандартын шаардлага хангуулсаны дараа байгальд /ус, хөрс/ нийлүүлэх арга хэмжээ авах;

2.6 Аймаг, нийслэлийн цэвэрлэх байгууламжийн цэвэрлэсэн бохир усанд гэдэсний бүлгийн эмгэгтөрөгч нян, гэдэсний бүлгийн савханцар E.Coli, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч, химийн хэрэгцээт хүчилтөрөгч, умбуур бодис гэсэн үзүүлэлтээр улирал тутам итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлнэ.

2.7 Цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас, бээлий, гутал, нүдний шил, нүүрний хамгаалалт, амны хаалт, гар халдваргүйжүүлэх уусмалаар тогтмол хангах;

2.8 Технологийн явцад үүсэх хорт хийн агууламжийг ажлын байруудад байнга хянаж байх дохиоллын системтэй байх;

2.9 Хорт хий ялгарах эрсдэлтэй орчинд ажиллах ажилтанд хорт бодисын ууршилтыг мэдрэх хувь хүний багаж / газ-детектор/-аар хангах;

2.10 Шаардлагатай тохиолдолд ажлын байрны агаарт үүссэн хорт хийнээс зугтах, авран хамгаалахад зориулсан /хөдөлгүүрт агаар цэвэршүүлэгч, агаарын хангамжтай амьсгалын аппарат, агаар нөөцлөгчтэй амьсгалын аппарат/ амьсгал хамгаалах хэрэгслийг хангалттай тоо хэмжээгээр ажлын байруудад бэлэн байлгах;

Гурав. Ахуйн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангаж ажиллах талаар:

3.1 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэдэг тээврийн хэрэгсэл, нийтийн эзэмшлийн хогийн саванд тогтмол цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийх;

3.2 Орон сууц, гэр хорооллын айл өрхийн хог хаягдлыг хуваарийн дагуу тогтмол зайлуулах, орон сууцны хог хаягдал түр цуглуулдаг савыг тогтмол угааж халдваргүйжүүлэх;

3.3 Орон сууцны орц, орчны газрын цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг өдөр тутам хийх, үйлчилгээний ажилчдыг амны хаалт, бээлий, гар халдваргүйжүүлэх уусмал зэрэг хөдөлмөр хамгааллын хувцсаар хангах;

3.4 Нийтийн эзэмшлийн газрын хог цэвэрлэдэг, хог ачиж, буулгадаг, тээврийн хэрэгслийн жолооч, хогийн цэгт ажиллаж байгаа ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас, маск, малгай, бээлий, гар халдваргүйжүүлэх уусмалаар хангаж ажиллах

Дөрөв. Эрүүл ахуй, халдвар хамгааллын нийтлэг шаардлага:

4.1. Ажилтнуудын халууныг өглөө бүр үзэж, халуунтай ажилтныг эрүүл мэндийн байгууллагад хандахыг зөвлөж буцаах;

4.2. Ажилтнууд амны хаалтыг тогтмол, зөв хэрэглэх, хэрэглэсэн амны хаалт, бээлий зэргийг хогийн саванд хаях;

4.3 Ажлын байр, бие засах газрыг 2 цаг тутам болон бохирдсон тохиолдол бүрт чийгтэй цэвэрлэгээ хийж, хог хаягдлыг тогтмол зайлуулах;

Ундны ус хангамж, ариун цэврийн байгууламж, хог хаягдлын менежментийн аюулгүй байдлыг хангаж ажиллах зөвлөмжийн дагуу хийсэн ажлын талаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт 2020 оны 12 дугаар сарын 01-ийн дотор албан бичгээр ирүүлэхийг мэдэгдье.

ДАРГА



Т.ГАНТУЛГА